

140 АРИУН СҮНСИЙГ ДАГА

140.1 ТЭНГЭРИЙН ХААНЧЛАЛЫН НУУЦ

Дэлхий нь Үгийг сонсдог ч ойлгохгүй байж болно. Дэлхий нь бэрхшээлийн дараах ерөөлүүдийг хардаггүй. Санаа зовоосон асуудлаас болоод дэлхий Үгийг дагаж чаддаггүй.

Сайн үр таригдсан талбайд дайсан ч мөн хогийн ургамал тарьж, тэд хамтдаа ургадаг.

Тэднийг ургац хураах өдөр тусгаарлана.

Тиймээс тэвчээртэй байгаарай. Муу муухайг сайнаар ялан дийл.

Эрдэнэс нуугдсан байдаг. Үнэ цэнийг нь хайж олоорой.

Сувдны үнэ цэнийг харах нүдтэй бай. Хэрэв та үүний үнэ цэнийг олсон бол оронд нь өөрт байгаа бүхий л зүйлээ зарах болно.

Торон дотроос сайн загас, муу загас байдаг. Хорон муугаас зөвтийг; дуулгаваргүй хүмүүсээс дуулгавартайг нь ялгах болно гэдгийг анхаар. Торон дахь загас бүр сайн байдаггүй. Тэнгэрийн хаанчлалыг гичийн үр гэж сургаалт зүйрлэлээр хэлсэн байдаг.

Гичийн үр бол хамгийн жижиг нь юм. Ургахдаа өсч том болдог.

Тэнгэрийн хаанчлалыг үр дүнтэй байгуулах хүч нь Бурханд байдаг.

Их Эзэнээс эмээх нь ерөөлийн хаалгыг нээж өгдөг. Энэ нь зөвт замыг олж харах сүнсийг тань хөглөн удирдаж өгдөг.

Их Эзэнээс эмээнэ гэдэг нь Түүний хэлснийг дуулгавартай дагахыг хэлдэг. Дэлхий шаргуу хөдөлмөрөөр зорилгоо биелүүлдэг бол Бурханы хүүхэд Эцэг Бурхандаа дуулгавартай дагаснаар зорилгодоо хүрдэг.

140.2 ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨХ : ТҮҮНИЙ ҮГЭНД ИТГЭ

Өөртөө зориулж бурхад бүү бүтээ.

Таньд ямар хүч байна вэ? Туршлага болон мэдлэг нь агаарын хүчнийг захирдаг уу? Бурханы хаант улс нь хэл ярианд биш, харин хүч дотор байдаг. Хувийн дүгнэлтээр эсвэл өөрийгөө дөвийлгөх үүднээс шүүж болохгүй.

Харин өөрийгөө Үг ба залбиралаар босгон байгуул.

Ариун Сүнсээр удирдуулж залбиран, бусдыг эдгээж, муу ёрын сүнснүүдийг хөөж, дээд өрөөний хүчийг хүлээн авч Үйлс номыг үргэлжлүүл. Түүний хаанчлал дэлхий дээр ирэх болтугай.

Мосетэй хамт ажилласан Бурхан өнөөдөр ч мөн адил.

Өөрийгөө бурхан бүү болго. Түүний хүслийг гүйцэлдүүл. Даруу, баяр хөөртэй дуулгавартай байдлаар биелүүл. Ехова Бурхан бол нигүүлсэнгүй, зөөлөн хайрлагч аав юм.

Тэр бидэнтэй сайн найз шиг бүх зүйлийг дэлгэрэнгүй ярилцахыг хүсдэг.

Хайр бол зөвхөн мэдэх тухай биш үйлдэх тухай юм. Зүрх сэтгэлийг цэвэр, ариун байлгах шалтгаан нь хүний зүрх сэтгэлийг өөрчлөх хүчтэй тэрхүү бэлгийг эзэмших явдал юм.

Дэлхий ертөнцийн хэлснээр бус харин Бурханы үгийн дагуу ажлаа хий. Бурханы хайр бол эх бүргэд дэгдээхэйгээ асарч байгаа шиг билээ.

Бүргэд жигүүр дээрээ дэгдээхэйгээ авч явдагтай адил Бурхан израильчуудыг хамгаалсан. Тэрээр өнөөдөр ч ард түмнээ тээсээр байна. Тэрээр зүрх сэтгэлээ бүрэн дүүрэн зориулсан хүнийг хүч чадал, амьдралаар ерөөхийн тулд дэлхийгээс хайж байна. Амь нь Ариун Сүнсэнд байдаг; Хүч нь Есүс Христэд байдаг. Тэр хүүхдүүддээ Өөрийн нэр ба хүч чадлыг өгсөн.

140.3 СУУРИЙН ШАЛГУУР:

ЗАЛБИРЛЫН ТАХИЛЫН ШИРЭЭГ СЭЛБЭХ/СЭРГЭЭХ

Ариун Сүнсний дуу хоолойг дагахгүй байгаа бол таньд итгэлийн ямар ч шинж, нотолгоо байхгүй юм. Иймд итгэлийн суурь үндэслэлээ даруухан, гэмшсэн сэтгэлээр эргэн хараарай.

- 1) Есүс Христ бол миний цорын ганц аврагч гэдэгт би итгэдэг үү?
- 2) Есүс Христ бол Бурханы Хүү гэдэгт би итгэдэг үү?
- 3) Есүс Христ онгон бүсгүй Мариагаас төрсөн гэдэгт би итгэдэг үү?

- 4) Намайг нүглээс аврахын тулд Есүс Христ загалмай дээр нас барсан гэдэгт би итгэдэг үү?
- 5) Есүсийн бие махбодиороо дахин амилсан гэдэгт би итгэдэг үү?
- 6) Есүс Христ тэнгэр лүү гарсан, мөн мөнх амьдарч буй гэдэгт би итгэдэг үү?
- 7) Есүс Христ эргэн ирж Библид бичигдсэн Бурханы амлалтуудыг биелүүлэнэ гэдэгт би итгэдэг үү?
- 8) Бурхан амьд ба үхэгсэд бүхнийг шүүж, Тэр дэлхийг захирах болно гэдэгт би итгэдэг үү?
- 9) Би Түүний хоёр дахь ирэлтийг хүлээж байна уу?
- 10) Есүс амласныхаа дагуу Ариун Сүнсийг илгээсэн гэдэгт би итгэдэг үү?

140.4 АРИУН СҮНСЭНД ДУУЛГАВАРТАЙ БАЙЖ ХАМТ АЛХАХ

Залбирахдаа Үгэн дотроос Эзэний дуу хоолойг сонсогтун.

Бурханы дуу хоолойг сонсвол

Та дээрээс ирэх хүчийг мэдрэх болно.

Үгийг эргэцүүлж бодохдоо

Та итгэлийг хүлээн авах болно.

Итгэлээ хөгжүүлэх үед та хүчийг мэдрэх болно.

140.5 АРИУН СҮНСТЭЙ ХАМТ АЛХАХ

Бурханы хүүхдүүд өдөр бүр залбирч, Үгийг эргэцүүлэн бодож бясалгах, мөргөл үйлдэх үедээ Ариун Сүнсээр дамжуулан амьд Эцэг–Бурхантай уулзах ёстой.

Есүс яагаад "Тэнгэрийн хаанчлалын хамгийн өчүүхэнээс " баптисм хүртсэнийг саная. Залбирлын өрөөний нууц газар, өөрийн нуувчин дотор төгс хүчит Бурханы жигүүр дор Бурхантай уулз. Залбирлын

тахилын ширээний өмнө Түүнтэй уулз. Залбирлынхаа өрөөнд орж Хүчирхэг Бурханы хамгаалалт дор залбир.

140.6 ГЭМШ: СҮНС ЮУ АЙЛДДАГИЙГ СОНСОГТУН

Гэмш, Ариун Сүнснийг итгэлээрээ хүлэн авагтун.

Өөрийнх нь үйлсийг гүйцэлдүүлэх нэгэнд хүчийг өгөхийн тулд Өөрт нь гуйвашгүйгээр хандаж чадах зүрх сэтгэлийг Бурхан хаа сайгүй хайж байна. Пентокостын өдрийн хүч нь Ариун Сүнсний онцгой бэлгээс ялгаатай юм. Таны бодол санаанд өөрийн хүсэл ба Ариун Сүнсний хүсэл холилдог. Ялгах чадварын хүчгүй бол Бурханы хүчирхэг ажлыг хийж байна гэж эндүү бодохвий.

Дагалдагчдыг томилсон шалтгаан нь та төөрөгдсөгдийн төлөө Христийн гэрч болон амьдрахын тулд юм. Бурханы Үгийг сонсож, гэмшиж, Есүсийн нэрээр гуйвал та итгэлээрээ Ариун Сүнснийг хүлээн авах болно.

Өөрийгөө шалгаж итгэлээрээ бат зогс. Таньд сайн үйлсийн мөр байгаа эсэхийг анзаар. Таны дотор Ариун Сүнсний оршихуй байгаа эсэхийг нягтал. Би Ариун Сүнснийг дагаж байна уу эсвэл махан биеийн хүслийг дагаж байна уу?

140.7 СЭРГЭЭ: ЭЗЭНИЙГ УРЬ

Урилгыг сонс

Бурханы хүүхэд өдөр бүр амьд Бурхантай уулзаж байх ёстой. Амилсан Христийг бүхий л зүрхээрээ тууштай хайж, Түүнтэй хувьчлан уулзах боломжтой гэдэгтээ итгэ. Бурхан бол Аврагч. Махан биеийн хүслийг хангахын тулд Бурханыг хайдаг хүмүүс Бурханыг мэддэггүй. Шунал нь шүтээн шүтэх явдал бөгөөд мэлмийг харалган болгож, сонорыг байхгүй болгож үхэлд хүргэдэг.

Бурхан, БИ БАЙДАГ, нь бүхий л ерөөлийн эх үүсвэр бөгөөд бидэнд Өөрийгөө илчлэхээ зогсоодоггүй. Тиймээс сонсоод Түүний урилгыг өнөөдөр хүлээн ав. Бүхий л ойлголт ба мэргэн ухаан болох Бурхан уруу ир. Бүх зүрх сэтгэл ,оюун бодлоороо хайвал Бурханыг олно. Эзэнийг хайрладаг хүмүүс нь Бурханы хайр, энэрлийг олно.

Түүний хайр бол анхны хайр бөгөөд тэрхүү анхны хайр бол ямагт анхны хайр юм.

Төгс хүнийг биш эмтэрсэн, гэмшсэн сүнснийг Бурхан хайдаг нь сайн хэрэг юм. Та бид өөрсдийн хаанчлал бус харин Түүний хаанчлалын төлөө ажиллаж буй бөгөөд сонссон зүйлдээ дуулгавартай байж, ойлгож итгэх хэрэгтэй.

Хөглөгдөж, чөлөөлөгдөгтүн.

Үйлсгүй итгэл нь үхмэл юм. Хөдөлмөргүй бодол нь хог , төлөвлөгөөгүй үйлдэл нь хариуцлагагүй юм. Бүү залхуур. Зориулалтын золиосыг ба чин стгэлийн хөдөлмөрийг өргө. Шоргоолжноос сур.

Үгийн дагуу үйлд. Төгсгөл хүртэл тэвч, бүү урва. Үгийн дуу хоолойг сонсож оюун бодлоо шинэчил. Үгийг зөвхөн өөртөө байшин байрихад зориулах биш харин Түүний хаанчлалыг барихын төлөө хичээ. Эзэн таныг нүглээс чөлөөлсөн. Дахиж гэм нүгэл бүү үйлд.

“ Би Эзэнийг хайрладаг” гэж хэлэх нь зохистой.

Үйлсгүй хайр бол байхгүйтэй адил юм. “ Эзэн надад таалагддаг” гэж хэлэх нь бус харин “ Би Эзэнийг хайрладаг” гэдэг нь зохистой илэрхийлэл юм. Эзэн таныг загалмай дээр амиа ч өргөн хайрласан юм.

Бурхан бидэнд төгс орчинг өгсөн. Өөрийг нь хайрладаг хүмүүсийн төлөө энэ дэлхийг Өөрийн элбэг хайраар бүтээсэн юм.

140.8 СЭРГЭЭ:ҮГИЙН ОЙЛГОХ

Сүнслэг хүн бай

Дагалдагч Филип Эзэний тэнгэр элчийн дууг дуулгавартай тэр даруй даган цөл рүү “ Өглөөний Шүүдэр” явсан. Библи бол амьд Бурханы Үг бөгөөд лавлагааны ямар нэгэн ном биш юм. Үүнд хэлсэн зүйлийг та дагадаг уу? Бичигдсэнчлэн бүх зүйлийг захирдаг Бурханыг сана. Арван хоёр шавийн дотроос сайн мэдээ түгээгээгүй, Ариун Сүнсний хүчийг хүлээж аваагүй хүн байсан уу? Ариун

Сүнсээр дүүрэхийн тулд та юу хийх ёстой вэ? Нүглээ улайж цэвэр болоод уйгагүй залбирч итгэлээрээ бүхнийг хүлээн авагтун. Ариун Сүнсээр дүүрэн байхын тулд үргэлжлүүлэн залбир.

Дээд өрөөний хүчийг олохын тулд бүрэн дүүрэн зүрх сэтгэлтэй байгтун.

Ариун Сүнсний баптизмын дараа дагалдагчид гэмшилд ойр байж бусдыг аврах үйлсэд хүчтэй гэрчлэгчид болсон. Итгэж хүлээсэн хүмүүс дээр Ариун Сүнс ирдэг. Энэ дэлхий дээр Эзэний ажил үйлсэд оролцдог итгэгчид нь Ариун Сүнсний хүчийг хүлээж авах хэрэгтэй. Гэмших, дагалдагч бий болгох зэрэг нь Сүнсний үйл ажиллагаа юм. Итгэлээр дамжуулан Бурханы хүүхэд болдог.

Нэг зүрх сэтгэлээр Сүнсний оршихуй дотор эмх журамтай магтаал хүндэтгэлийг өргө. Хайр дотор нөхөрлөлийн эв нэгдлийг хадгал.

140.9 ШИНЭЧИЛ:ЧИГЛЭЛ

Ариун Сүнсэнд захирагд

Үр дүнгийн төлөө бүү шанал. Харин Ариун Сүнсэнд захирагд. Өөрийн мэдлэг, туршлага, бодол эсвэл итгэлийн үйлсийн энгийн ойлголт зэрэгт биш харин Ёховаг мэдэх мэдлэгээс гарах үйлсээр үйлд. Ариун Сүнсийг дагаж сүнслэг хүн болж Ариун Сүнсээр дүүр.

140.10 ҮР ЖИМС

Үр жимсийг шалга

Ариун ууланд хэн амьдардаг вэ? Түүний асарт хэн оршдог вэ? Хууль хаанаас гардаг вэ? Хуулийг хэн сахидаг вэ? Хуулийг хэн заадаг вэ? Тэднийг үр жимсээр нь тань гэж Эзэн хэлдэг.

Хүмүүсийн үр жимсийг ажиглаад үнэн эсвэл худлыг нь тань гэж Эзэн хэлдэг. Үнэн үр жимс нь Бурханаас ирдэг. Түүний тушаалыг дагасны үр дүнд олон үр жимс гардаг. Суралцаад дагах хэрэгтэй. Шалгуурын дараа үр жимс ирдэг.

Хуваалцах үр жимс

Сахлаг ургамлын навчис жимслэхгүй бол ашиггүй. Навчис нь жимс боловсруулахын тулд бөгөөд жимснүүд нь хуваалцахын тулд байдаг. Жимснүүд нь зөвхөн таньд зориулагддаггүй.

Ерөөгдсөн зүрх сэтгэлээс Амьд Бурханыг алдаршуулдаг үр жимс ургаж өөрийнх нь сүнсийг хангалуун болгодог. Энэ нь Бурханы манна юм. Ерөөлийн цаг хугацааг ялган тань. Бүх зүйлд цаг хугацаа байдаг. Бурхан хэрхэн өгдөгийг тань. Тэр хэзээ, хаана таныг ерөөсөн бэ? Хэрхэн, хэнээр дамжуулж ерөөсөн бэ? Бурханы арга замд анхаарлаа хандуулбал Түүний ерөөлийн нууцыг та ойлгох болно. Өөрийн боломжийг бүү алд.

Цаг нь болсон үр жимс

Та Үгийг мэдээд, итгэлээр алхдаг ч зөрүүдлэл, ихэрхэл, бардам бодолтой ба өөрийнхийг Бурханыхтай хольж амьдарч байх вий. Зарим хүмүүс бүхий л зүйл дээрээ Бурханы Үгээр амьдардаг. Бурханы Үгийг анхааралтай сонсож бүх зүйлдээ үүгээр амьдрах замаар зөвт замд алхдаг. Өөрийн эсвэл найз нөхөд, бусад хүмүүсийн хүслийн замаар алхдаг бол нүгэлтний замаар явж буй юм. Ямар төрлийн үр жимс гаргаж байна вэ? Ямар замаар та алхаж байна вэ? Үр жимсээ цагт нь ургуулж байна уу? Таны ажил Ариун Сүнсний жимсийг гаргаж байна уу? Христ дотор хамт байж Үгийг дагавал таны мөчирнөөс үр жимс ургана.

Үгийг хэрхэн дагаснаар өөрийн амьдралаа бүтээдэг. Тариалах ба хураахын хоорондын холбоог ойлго. Эргэлзээн дунд тариалаад үр дүн хүлээдэг үү та? Хөрсөө сайн бэлдсэн үү?Таны гичийн үр юу вэ? Хамгаалалтын төлөвлөгөө байгаа юу?

140.11 СҮНСЭЭР ДҮҮРЭН АМЬДРАЛ

Ерөөлтэй амьдрал гэдэг нь Бурханд итгэж, хуулийг сонсож сахиж хэрэгжүүлэх, Бурханд найдаж сайн мэдээг тунхаглаж, Түүнийг амьд гэдэгт итгэж, Түүний үнэмлэхүй хүч чадалд итгэж Түүнд бүх санаа зовнилоо үүрүүлж бэрхшээл зовлонгийн үед айхгүй байж, гамшгийн үед санаа зовохгүй байж, махан биеийн хүсэл, шуналыг үл дагаж өөрийгөө өргөмжлөхгүй байх юм. Энэ төрлийн амьдрал

нь цөлд маннаг хүлээж авдагтай адил юм. Хэрэв нэг хүн Ариун Сүнсээр 100 % дүүрэн байж чадвал энэ дэлхий ямар өөр байх бол? Ариун Сүнсээр та хэдэн хувь дүүрэн байна вэ? Та Сүнсээр дүүрэн хүн үү? Таны хувьд Есүс хэн бэ? Фараон “ Сүнсээр дүүрэн тийм хүнийг хаанаас олох вэ?” гэж асуунгуутаа Иосефийг тохирох хүн гэдгийг мэдсэн. Сүнсээр дүүрэн хүнийг та таних уу?